

Эрсдэлд суурилсан ХАБЭА-н бодлогын тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Д.Болдмаа, Г.Мөнхзориг
Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний Даблью Эйч Эй ХХК
Email: boldmaa@wha.mn, munkhзориг@wha.mn
www.wha.mn

Хураангуй

Түлхүүр үг: ажлын байр, эрүүл мэндийн их эрсдэл, ижил өртөлтийн бүлэг

Зорилго: Эрсдэлд суурилсан Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ХАБЭА-н бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах үндэслэл, зөвлөмж боловсруулах.

Арга зүй: Нэгэн агшингийн судалгааны загвараар Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний аргачлал Good Practice Guidance on Occupational Health Risk Assessment (2017, ICMM) -ын 1, 2, 3 дугаар түвшний эрсдэлийн үнэлгээний арга, Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам (2015, ХНХЯ)-ыг ашиглаж нийт 6 салбарын 22 байгууллагын 777 ажлын байранд¹ ажиллаж буй 3516 ажилтныг хамруулан Эрсдэлд суурилсан Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2018-2019 онд хийлээ. Тоон мэдээллийг IHSTAT-V225, IDSTAT+V101 (2007, АИНА) програмыг ашиглан боловсрууллаа.

Үр дүн: Үнэлгээ хийлгэсэн 22 байгууллагаас 20 байгууллагад буюу 91%-д нь их болон маш их эрсдэл илэрсэн бөгөөд энд уушигны цулцанд нэвтрэх тоос, уушигны цулцанд нэвтрэх цахиур агуулсан тоос, химийн бодис, шуугиан, халуун хүйтэн температур, биеийн хүчний ажил, биологийн, цацрагийн эрсдэл орж байна.

Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтооход хамаарах жагсаалтыг батлах тухай 77-р тушаалын жагсаалтын дагуу тодорхойлсон Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажлын байрны 89% нь Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон Их эрсдэлтэй тохирч байна. Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр Их эрсдэлтэй гарсан ажлын байрны 21%(99 ажлын байр) нь Хөдөлмөрийн хэвийн бус ангилалд хамрагдаагүй байна.

Дүгнэлт: Тухайн байгууллагын ажлын ачаалал, технологийн онцлог, ХАБЭА-н удирдлага, хэрэгжилтийн түвшнээс хамаарч ижил ажлын байранд өөр өөр

¹ “Байнгын ажлын байр” гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүргийг хэлнэ.

байгууллагад ажилладаг ажилтнуудын Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн түвшин ялгаатай байна.

1. Үндэслэл

Монгол Улсын нийт хүн амын 63.2% (2,007,430) нь хөдөлмөрийн (15-60) насны хүн ам байна. Эдгээр хүн амын 1,367,280 нь эдийн засгийн идэвхтэй хүн ам юм. Улсын хэмжээнд 2019 оны 12 сарын байдлаар бүртгэлтэй нийт 88,855 компанид 700,000 гаруй хүн ажиллаж байна.

Өнөөдөр улсын хэмжээнд 9880 мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдол гарсан ба үүнээс 2017 оны байдлаар 3336 өвчтөн нь идэвхитэй хяналтанд байна. Эдгээр ажилчдын 93% нь хүнд үйлдвэр, уул уурхай, барилга, зам тээвэр, эрчим хүчний салбарын, 99% нь 6 аас дээш жил ажилласан, 74% нь 41-60 насны, 93% нь 50-аас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан байна.

Мэргэжлээс шалтгаалах өвчний бүтцийг авч үзэхэд: 54% уушигны гадны шалтгаант өвчин, 27% мэдрэл, мэдрэлийн ёзоор ба сүлжээний өвчин, 9% химийн хүчин зүйлийн нөлөөнөөс үүссэн өвчин, 8.9% тулгуур хөдөлгөөний эрхтний ба хөх судасны өргөсөх өвчин, 0.9% биологийн хүчин зүйлийн нөлөөнөөс үүссэн өвчин, 0.4% ионжуулагч цацрагийн нөлөөнөөс үүссэн өвчин тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд 2009-2017 онд үйлдвэрлэлийн ослын 3321 тохиолдол бүртгэгдсэн. Үйлдвэрийн ослын улмаас 509 хүн нас барж, 761 хүн гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж, 2051 хүн хөдөлмөрийн чадвараа түр алдсан байна. 2017 оны байдлаар 3336 хүн МШӨ-өөр ХЧА-ын тэтгэмжийг Нийгмийн Даатгалын сангаас авсан байна.

Хэдийгээр холбогдох хууль, журам, стандартын шаардлагын баримт бичгүүд хангалттай байгаа боловч улсын хэмжээнд Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэсэн аж ахуйн нэгж байгууллага 48.3 хувь байгаа² нь хангалтгүй байна.

Ажил олгогчдын энэхүү хэрэгцээг хангах зорилгоор Даблью Эйч Эй компани 2018 онд байгуулагдан, MNS ISO/IEC17020 стандартаар итгэмжлэгдэж эрсдэлд суурилсан Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хэрэгжүүлж эхлээд байна.

² ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, 2017, ХНХЯ

2. Зорилго: Эрсдэлд суурилсан Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний үр дүнд үндэслэн ХАБЭА-н бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах үндэслэл, зөвлөмж боловсруулах

3. Зорилт

1. Даблью Эйч Эй ХХК-ийн “Эрсдэлд суурилсан Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”-нд 2018-2019 онд хамрагдсан байгууллагуудад тодорхойлогдсон “Их” эрсдэлүүдийг төрөл, салбараар гаргах
2. Тодорхойлогдсон хөдөлмөрийн “Хэвийн бус” нөхцөл, эрүүл мэндийн “Их” эрсдэл хооронд харьцуулалт хийж, ХАБЭА-н бодлогод оруулах өөрчлөлтийн зөвлөмж боловсруулах

4. Судалгааны хэсэг

Арга зүй: Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний аргачлалд Good Practice Guidance on Occupational Health Risk Assessment (2017, ICMM)-г ашиглав.

А.Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний үе шат

Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг дараах үндсэн үе шатаар хэрэгжүүллээ. Үүнд:

Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний түвшин 1 дүгээр үе шат. Энэ үе шатанд ажилтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг ажлын байрны хүчин зүйл(аюул)-ийг таньж илрүүлэн, түүнээс эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээллийг цуглуулж, ажлын байруудыг ижил төстэй өртөлтөөр нь бүлэглэх ажлыг хэрэгжүүллээ. Энэ үе шатанд цуглуулсан мэдээлэл, өртөлтийн бүлэгт үндэслэсэн хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэлээ.

Ажлын байрны сөрөг хүчин зүйлс гэдэгт үйлдвэрийн технологи, үйл ажиллагаа, орчин, цаг уур, тоног төхөөрөмж, түүхий эд, эцсийн бүтээгдэхүүн, хог хаягдал зэрэгтэй холбоотойгоор бий болдог хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хими, физик, биологи, эргономикийн хүчин зүйлсийг хамааруулав.

Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний түвшин 2 дугаар үе шат.

Өмнөх үе шатанд тодорхойлогдсон ажлын байрны ижил өртөлтийн бүлэг (ИӨБ) бүр дэх эрүүл мэндийн аюулын төрөл, тэдгээрийн шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, эх үүсвэр, эрүүл ахуйн талбайн болон хувь хүний өртөлтөнд хийсэн хэмжилтийн дүн, хяналтын арга хэмжээний мэдээллийг эрсдэлийг үнэлэхэд

ашиглав. Улмаар сөрөг хүчин зүйлсийн өртөлтийн түвшин, түүнд өртөх давтамж, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон хэмжилт шинжилгээний үр дүнд үндэслэн чанарын болон тоон аргаар эрсдэлийг үнэлэв.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт хийхэд MNS ISO/IEC 17025 стандартаар итгэмжлэгдсэн Хөдөлмөр, Орчны эрүүл ахуйн лабораториудтай хамтран ажиллав.

Эрсдэлийн үнэлгээнд ажлын байранд тодорхойлогдсон аюул бүрээс ажилтны эрүүл мэндэд учруулах сөрөг үр дагавар, өртөлтийн түвшин, өвчлөл тохиолдох магадлалыг үнэлэхэд 5 x 5 эрсдэлийн үнэлгээний матрицыг ашиглав. Улмаар Ижил өртөлтийн бүлэг бүрийг эрүүл мэндийн эрсдэлийн түвшнээр нь маш их, их, дунд, бага эрсдэлтэй гэж ангиллаа.

Эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний түвшин 3 дугаар үе шат.

Маш их болон их эрсдэлтэй ажлын байруудыг дараагийн шатны үнэлгээ болох түвшин 3 үе шатны үнэлгээнд хамрууллаа.

Б.Ажлын байрны Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх үе шат: Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 тушаал, Ажлын байрны Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж батлах тухай, 2016, ХАБЭА-н Үндэсний хорооны дугаар 01 тогтоолыг үндэс болгов.


Үр дүн

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан байгууллагуудыг салбараар нь авч үзвэл 30% нь Уул уурхай, түлш, эрчим хүчний салбар, 30 % нь хүнс, хөнгөн үйлдвэрийн салбараас, 25% нь засвар, эд ангийн үйлдвэрээс, 15% нь эрүүл мэнд, батлах хамгаалах, боловсролын салбараас хамрагдсан байна.



Үнэлгээнд хамрагдсан нийт 22 байгууллагаас 16 нь Улаанбаатар хотоос, 6 байгууллага орон нутгаас хамрагдсан байна. Эдгээр байгууллагын 19 нь буюу 86% нь анхны удаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн бөгөөд үйл ажиллагаа явуулсан дундаж хугацаа 16 жил байна.

Үнэлгээ хийлгэсэн 22 байгууллагаас 20 байгууллагад буюу 91%-д нь их болон маш их эрсдэл илэрсэн бөгөөд энд уушигны цулцанд нэвтрэх тоос, уушигны цулцанд нэвтрэх цахиур агуулсан тоос, химийн бодис, шуугиан, халуун хүйтэн температур, биеийн хүчний ажил, биологийн, цацрагийн эрсдэл орж байна.



Зураг 2. Маш их эрсдэл гэдэг нь Олон хүнийг хамарсан хөдөлмөрийн чадвар алдуулах өвчлөл, нас баралт.

Үүнд: хавдар, эд эсэд мутацн үүсгэх, үр удамд нөлөөлөх, нөхөн үржихүйн эрхтэнд үзүүлэх эргэжгүй нөлөөлөл

Их эрсдэл гэдэг нь Нэг хүний амь нас эндэх, эрүүл мэндийн эргэжгүй өөрчлөлт, хөдөлмөрийн чадварт алдалтад хүргэх өвчлөл хамаарна. Үүнд: хавдар, эд эсэд мутацн үүсгэх, үр удамд нөлөөлөх, нөхөн үржихүйн эрхтэнд сөргөөр нөлөөлөх хордлогууд, давшингүй хэлбэрийн архаг, хурц хэлбэрийн өвчлөл

Хүснэгт 1. Тодорхойлогдсон Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл болон ИХ эрсдэлийг харьцуулбал,

Ажлын нөхцөл	Их эрсдэл тодорхойлогдсон	Нийт
Хэвийн бус	278 (89%)	312
Хэвийн	99 (21%)	465
Нийт	377 (48%)	777

Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтооход хамаарах жагсаалтыг батлах тухай 77-р тушаалын жагсаалтын дагуу тодорхойлсон Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажлын байрны 89% нь Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон Их эрсдэлтэй тохирч байна, 11% нь тохироогүй байна (Хүснэгт 1).

Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээгээр Их эрсдэлтэй гарсан ажлын байрны 21%(99 ажлын байр) нь Хөдөлмөрийн хэвийн бус ангилалд хамрагдаагүй байна.

Хүснэгт 2. Ажлын байранд тодорхойлогдсон тоос, шуугианы хувь хүний өртөлтийн түвшнийг ажлын 8 цаг болон 12 цагийн өртөлтийн зөвшөөрөгдөх хэмжээтэй харьцуулсан дүн

	Шуугиан		Тоос			
	8 цаг	12 цаг	8 цаг		12 цаг	
			Цулцанд нэвтэрдэг 3 мг/м3(8ц)	Цахиур агуулсан 0.1мг/м3(8ц)	Цулцанд нэвтэрдэг 2 мг/м3(12ц)	Цахиур агуулсан 0.06мг/м3(12ц)
ЗДХ	85 dB(A)	83 dB(A)				
Хэмжилтийн тоо	104	99	79	21	85	23
Арифметикийн дундаж утга	94.97	89.1	1.4	0.125	0.52	0.012
Стандарт хазайлт	7.1	2.9	2.9	0.278	2.13	0.009
ЗДХ-ээс хэтэрсэн хувь	46.2%	67.7%	13.9%	23.8%	4.7%	0%
ХИ утга	100.6	97	18.9	0.88	12.84	0.032
ХБ утга	57.4	63	0.004	0.002	0.038	0.0012

Шуугианы хувь хүний өртөлтөнд нийт 203 хэмжилт хийснээс дундаж утга нь 95 dB(A)8цаг, 89 dB(A)12цаг, ЗДХ-ээс хэтэрсэн хувь 46.2% 8 цаг, 67.7% 12цаг байна.

Уушигны цулцанд нэвтрэх тоосны нийт 208 хэмжилт хийснээс дундаж утга нь 1.4 мг/м3(8ц), 0.52 мг/м3(12ц), ЗДХ-ээс хэтэрсэн хувь 13.9% 8 цаг, 4.7%12 цаг, цахиур агуулсан тоосны дундаж утга нь 0.125 мг/м3(8ц), 0.012мг/м3(12ц), ЗДХ-ээс хэтэрсэн хувь 23.8% 8 цаг, 0%12 цаг байна.

Үр дүнгийн хэлцэмж

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарагдах ажлын байрны жагсаалтыг батлагдсан аргачлалаар эрх бүхий байгууллагаар доод тал нь 2 удаа хийлгэж баталгаажсан эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэслэдэг болох

Дүгнэлт

Хөдөлмөрийн эрүүл мэндийн Их эрсдэл уул уурхай, дэд бүтцийн салбарт зонхилон тохиолдож байгаа хэдий ч үнэлгээнд хамрагдсан нэг эрүүл мэндийн байгууллагад химийн бодис, биеийн хүчний ажил, халуун хүйтэн температур, цацраг, биологийн хүчин зүйл Их эрсдэлтэй гарсан байгаа нь уул уурхай, хүнд үйлдвэрийн салбараас бусад салбарын байгууллагууд Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагддаггүй, ХАБЭА-н удирдлагын зохицуулалт дутагдалтай байгааг харуулж байна.

Тухайн байгууллагын ажлын ачаалал, технологийн онцлог, ХАБЭА-н удирдлага, хэрэгжилтийн түвшнээс хамаарч ижил ажлын байранд өөр өөр байгууллагад ажилладаг ажилтнуудын Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн түвшин ялгаатай байна.

Санал зөвлөмж:

Эрүүл ажлын байр шалгаруулах шалгуур үзүүлэлтэд Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн, ажлын байранд буй хөдөлмөрийн эрүүл мэндийн Их эрсдэлүүдийг бүрэн хяналтандаа авсан, бууруулсан байх гэдэг шалгуурыг оруулах

Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний арга аргачлалыг боловсронгуй болгож ижил өртөлтийн бүлгээр хянадаг Хөдөлмөрийн эрүүл мэндийн удирдлагын олон улсын аргачлалын зарчмыг оруулах

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах журам батлах тухай Эрүүл мэндийн сайдын А/340 дүгээр тушаалаар зөвлөмжилсөн эрүүл мэндийн үзлэгний төрөл, давтамжийг ажлын байрны эрүүл мэндийн эрсдэлийн төрөл, түвшингээс хамааруулж зохион байгуулах журмыг шинэчлэх

Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамрагдсан ажилтнуудын эрүүл мэндийг онцгойлон анхаарч хамгаалах, эрсдэлийг бууруулах, хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллуулах боломж бүрдүүлэхэд цаашид бүх түвшиндээ анхаарч ажиллах нь зүйтэй.

Ашигласан материал:

1. Даблью Эйч Эй ХХК-ийн эрүүл ахуйн хэмжилтийн нэгдсэн дүн
2. Хөдөлмөрийн эрүүл ахуй, 2013, Л.Оюунтогос, Д.Нарансүх
3. Fundamentals of industrial hygiene, 6th edition, 2012, Barbara A.Plog, Patricia J.Quinlan
4. Chemical hazards assessment and control, 2003, UNSW, Australia
5. Basics of Epidemiology, 2003, UNSW, Australia
6. Occupational hygiene controls, 2002, UNSW, Australia
7. Occupational hygiene hazards, 2003, UNSW, Australia
8. Introduction to Injury risk assessment, 2003, UNSW, Australia